



**ХУУЛЬ ЗҮЙН
ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭНГИЙН
ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2021 оны 12 сарын 14 өдөр

Дугаар 4/64


Улаанбаатар хот

Г
Журам батлах тухай
Г

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2020 оны 09 дүгээр сарын 10-ны өдрийн А/158 дугаар тушаалаар баталсан Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн дүрмийн 4 дүгээр зүйлийн 4.4 дэх хэсэгт заасныг үндэслэн ТУШААХ НЬ:

1. "Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Эрдмийн зөвлөлийн ажиллах журам"-ыг энэхүү тушаалын 1 дүгээр хавсралтаар, "Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Эрдмийн зөвлөлийн бүрэлдэхүүн"-ийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Энэ тушаал гарсантай холбогдуулан "Эрдмийн зөвлөл байгуулах тухай" Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирлын 2017 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн А/06 тоот тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.
3. Уг журмыг энэхүү тушаал гарсан өдрөөс эхлэн мөрдөж, тушаалын хэрэгжилтийг ханган ажиллахыг Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга /С.Сүхбаатар/-д үүрэг болгосугай.

ЗАХИРАЛ



Х.ЭРДЭМ-УНДРАХ

Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирлын
2021 оны 12 дугаар сарын 14-ны
өдрийн A/64 тушаалын
нэгдүгээр хавсралт

**ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭНГИЙН
ЭРДМИЙН ЗӨВЛӨЛИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1 Энэхүү журмын зорилго нь Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн /цаашид “Хүрээлэн” гэх/ дүрмийн дөрөвдүгээр зүйлд заасан чиг үүргийн хүрээнд Эрдмийн зөвлөлийн /цаашид “Зөвлөл” гэх/ үйл ажиллагааны бүтэц зохион байгуулалт, хуралдааныг зохион байгуулах, асуудал хэлэлцэх, санал хураах, шийдвэр гарах хурлын дэг, журамтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.
- 1.2 Зөвлөл нь эрдэм шинжилгээ, судалгаа, сургалт, мэдээлэл, сурталчилгааны бодлогод чиглэл өгөх, зөвлөх үүрэгтэй байна.
- 1.3 Зөвлөл нь орон тооны бус байна.
- 1.4 Зөвлөл нь Монгол Улсын хууль тогтоомж, хүрээлэнгийн дүрэм болон энэхүү журмын хүрээнд үйл ажиллагаа явуулна.
- 1.5 Зөвлөл нь Хүрээлэнгийн судалгаа, сургалт, мэдээлэл, сурталчилгааны ажлын үндсэн чиглэл өгөх, хэрэгжилтийг хэлэлцэж үнэлэлт өгөх, санал, дүгнэлт гаргах, судалгааны ажлын сэдэв, сургалтын хөтөлбөрт зөвлөмж гаргах зэрэг чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Хоёр. Зөвлөлийн удирдлага, бүрэлдэхүүн

- 2.1 Зөвлөл нь зөвлөлийн дарга, нарийн бичгийн дарга, гишүүдээс бүрдэнэ.
- 2.2 Зөвлөлийн бүрэлдэхүүнийг Хүрээлэнгийн захирал батална.
- 2.3 Зөвлөлийн үйл ажиллагааг зөвлөлийн дарга удирдана.
- 2.4 Зөвлөлийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах асуудлыг Хүрээлэнгийн захирлын тушаалаар шийдвэрлэнэ.
- 2.5 Хүрээлэнгийн захирал нь зөвлөлийн гишүүн байна.

Гурав. Зөвлөлийн үйл ажиллагааны чиг үүрэг

- 3.1 Зөвлөлийн үйл ажиллагааны зорилго нь Хүрээлэнгийн эрдэм шинжилгээ, судалгаа, сургалт, сурталчилгаа, мэдээллийн ажлын үндсэн чиглэлийг тодорхойлох, төлөвлөлт, түүний хэрэгжилтийн явц, үр дүнг хэлэлцэж үнэлэлт өгөх, санал, дүгнэлт гаргах, судалгааны ажлын сэдэв, сургалтын хөтөлбөрт зөвлөмж өгөх, гадаад улсын ижил төстэй байгууллагатай харилцаа тогтоож хамтран ажиллахад дэмжлэг үзүүлэх, хууль зүйн судалгааны бусад байгууллага, их, дээд сургуулиудтай хамтран ажиллах зэргээр

Хүрээлэнгийн эрдэм шинжилгээ, судалгаа, сургалтын үйл ажиллагааны чадамжийг дээшлүүлэхэд оршино.

3.2 Зөвлөл нь Хүрээлэнгийн үйл ажиллагаатай холбоотой дараах асуудлуудыг хэлэлцэн зөвлөмж гаргана. Үүнд:

- 3.2.1. Хүрээлэнгийн хөгжлийн бодлого, хэтийн төлөвийг тодорхойлсон баримт бичгийн төсөл;
- 3.2.2. Хүрээлэнгийн эрдэм шинжилгээ, судалгаа, сургалт, сурталчилгаа, мэдээллийн ажлын тэргүүлэх чиглэл, цаашдын зорилгыг хэлэлцэн тодорхойлох тухай;
- 3.2.3. Хүрээлэнгээс санаачлан хэрэгжүүлж буй үндэсний болон олон улсын хэмжээнд зохион байгуулсан эрдэм шинжилгээ, судалгааны ажил, сургалт, сурталчилгаа, мэдээллийн төсөл, хөтөлбөрүүдийн явц, үр дүнг хэлэлцэн цаашдын үйл ажиллагааны чиглэлийн тухай;
- 3.2.4. Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн 2021-2024 оны үйл ажиллагааны стратеги төлөвлөгөөний 1.3-т заасан гадаад улсын ижил төстэй байгууллагатай харилцаа тогтоох, хамтран ажиллахад дэмжлэг үзүүлэх;
- 3.2.5. Эрдэм шинжилгээний бүтээлийг хэлэлцэн олон улсын, дотоодын болон гадаадын шагналд тодорхойлох;

Дөрөв. Зөвлөлийн даргын эрх, үүрэг

4.1 Зөвлөлийн дарга дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

- 4.1.1. Зөвлөлийн хуралдааныг удирдах;
- 4.1.2. Зөвлөлийн хуралдааныг хүрээлэнгийн захиралтай зөвшилцэн зарлах;
- 4.1.3. Зөвлөлийн хуралдаанаас гарсан зөвлөмжийг гарын үсэг зурж албажуулна.

Тав. Зөвлөлийн нарийн бичгийн даргын эрх, үүрэг

5.1 Хүрээлэнгийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга нь Зөвлөлийн нарийн бичгийн дарга байна.

5.2 Зөвлөлийн нарийн бичгийн дарга дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

- 5.2.1. Зөвлөлийн үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх, тайлагнах;
- 5.2.2. Зөвлөлийн чиг үүргийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааг дүрмийн дагуу тасралтгүй, үр ашигтай зохион байгуулах нөхцөлийг хангах;
- 5.2.3. Зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэх асуудлын саналыг боловсруулаж зөвлөлийн даргад танилцуулах;
- 5.2.4. Зөвлөлийн хуралдааны бэлтгэл ажлыг хангах;

- 5.2.5. Зөвлөлийн хуралдаанаас гарсан зөвлөмж, хуралдааны тэмдэглэлийг архивт хадгалуулах;
- 5.2.6. Зөвлөлийн хуралдааны талаарх мэдээлэл бэлтгэж түгээх;
- 5.2.7. Зөвлөлийн хуралдааны шийдвэрийн хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах;

Зургаа. Зөвлөлийн гишүүний эрх, үүрэг

- 6.1 Эрдмийн зөвлөлийн гишүүн нь дараах эрхтэй. Үүнд:
 - 6.1.1. Хэлэлцэж буй асуудлаар санал бодлоо чөлөөтэй илэрхийлэх;
 - 6.1.2. Хэлэлцэж буй асуудлыг шийдвэрлэхэд таслах эрхтэйгээр оролцох;
 - 6.1.3. Зөвлөлийн хуралдаанд хэлэлцүүлэх асуудлын талаар санал оруулах;
 - 6.1.4. Зөвлөлийн хуралдаанаас гарсан зөвлөмжийн биелэлтийг хангахад дэмжлэг үзүүлэх;
 - 6.1.5. Хуралдааны хэлэлцүүлэгт хамаарах асуудлаар шаардлагатай мэдээллийг хүрээлэнгээс гаргуулан авах;
 - 6.1.6. Хүндэтгэн үзэх шалтгааны улмаас Зөвлөлийн хуралдаанд биечлэн оролцох боломжгүй болсон бол энэ тухайгаа зөвлөлийн нарийн бичгийн даргад урьдчилан мэдэгдэж хэлэлцэх асуудлаар саналаа бичгээр болон цахим хэлбэрээр хүргүүлэх;
 - 6.1.7. Зөвлөлийн гишүүнээс өөрийн хүсэлтээр татгалзах;
- 6.2 Зөвлөлийн гишүүн дараах үүргийг хүлээнэ. Үүнд:
 - 6.2.1. Зөвлөлийн хуралдаанд биечлэн оролцох;
 - 6.2.2. Зөвлөлийн хэлэлцэх асуудал, байгууллагын дотоод үйл ажиллагаатай холбоотой нууцыг хадгалах;

Долоо. Зөвлөлийн хуралдаан

- 7.1 Зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь Зөвлөлийн хуралдаан байна.
- 7.2 Гишүүдийн олонх оролцсон хуралдааныг хүчинтэйд тооцно.
- 7.3 Зөвлөлийн хуралдааныг зөвлөлийн дарга Хүрээлэнгийн захиралтай зөвшилцэн зарлаж хуралдуулах бөгөөд хуралдааныг зөвлөлийн дарга, түүний эзгүйд тус Хүрээлэнгийн захирлын шийдвэрээр зөвлөлийн гишүүдээс аль нэг гишүүнийг сонгон удирдуулна.
- 7.4 Хуралдааны дэгийг хуралдааны дарга зөвлөлийн гишүүдийн саналыг үндэслэн хуралдаан бүрийн эхэнд тогтооно.
- 7.5 Зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг ажлын 5-аас доошгүй өдрийн өмнө гишүүдэд танилцуулж, холбогдох материалыг хүргүүлнэ.

- 7.6 Зөвлөлийн хуралдаанаас гарах зөвлөмжийг хуралдаанд оролцсон гишүүдийн ердийн олонхийн саналаар гаргана. Зөвлөмжийг хуралдааны дарга, нарийн бичгийн дарга гарын үсэг зурж албажуулна.
- 7.7 Хуралдаанд оролцоогүй гишүүнд хурлын шийдвэрийг зөвлөлийн нарийн бичгийн дарга танилцуулна.
- 7.8 Зөвлөлийн хуралдааны тэмдэглэлийг хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан хөтөлж ажлын 3 хоногт багтаан Зөвлөлийн дарга, нарийн бичгийн дарга хянаж гарын үсэг зурж баталгаажуулна.
- 7.9 Зөвлөлийн гишүүнд зохих урамшуулалт олгож болно.
- 7.10 Зөвлөлийн хуралдааныг танхимаар хуралдуулах боломжгүй нөхцөл байдал үүссэн тохиолдолд цахимаар хуралдуулж болно. Цахимаар хурал зохион байгуулах тохиолдолд хэлэлцэх асуудал, хуралдааны тов, зохион байгуулалтын мэдээллийг 5-аас доoshгүй өдрийн өмнө зөвлөлийн гишүүдэд илгээнэ.

Найм. Зөвлөлийн шийдвэрийн биелэлтийг хангах

- 8.1 Зөвлөлийн хуралдааны шийдвэрийн биелэлтийг хангах ажлыг зохион байгуулах үүргийг зөвлөлийн нарийн бичгийн дарга хариуцна.
- 8.2 Зөвлөлийн хуралдааны шийдвэрийн хэрэгжилт, явц, үр дүнг зөвлөлийн ээлжит хуралдаанаар танилцуулна.
- 8.3 Зөвлөл нь хүрээлэнгийн тамга, тэмдэг, албан маягт хэрэглэнэ.

Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирлын
2021 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн
A/64 тушаалын 2 дугаар хавсралт

**ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭНГИЙН
ЭРДМИЙН ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

Эрдмийн зөвлөлийн дарга:

Төрийн шагналт, Монгол Улсын шинжлэх ухааны гавьяат ажилтан, Хууль зүйн шинжлэх ухааны доктор, профессор, Академич С.Нарангэрэл

Эрдмийн зөвлөлийн гишүүд:

Монгол Улсын гавьяат хуульч, Хууль зүйн шинжлэх ухааны доктор, профессор Ц.Сарантуяа

Монгол Улсын гавьяат хуульч, Хууль зүйн шинжлэх ухааны доктор, профессор Д.Лүндээжанцан

Хууль зүйн ухааны доктор, профессор Б.Уранцэцэг

Хүний эрхийн үндэсний комиссын гишүүн, Хууль зүйн ухааны доктор Д.Сүнжид

Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал, Хууль зүйн ухааны доктор Х.Эрдэм-Үндрэх

Отгонтэнгэр их сургуулийн Хууль зүйн сургуулийн захирал, Хууль зүйн ухааны доктор Д.Эрдэнэчимэг

Хууль зүйн ухааны доктор Э.Батбаяр

Эрдмийн зөвлөлийн нарийн бичгийн дарга:

Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга, Хууль зүйн ухааны доктор С.Сүхбаатар